

Гаалийн ерөнхий газарт хэрэгжиж буй “Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах” төсөл
Бүрэлдэхүүн 2: “Хилийн хяналтын удирдлагын систем”-ийн мэдээлэл

№	Агуулга	Утга
1	Төсөл, арга хэмжээний нэр:	“Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах” МОН-3313 төсөл
2	Төсөл хэрэгжүүлэгч байгууллага:	Сангийн яам
3	Төсөл гүйцэтгэгч байгууллага:	Гаалийн ерөнхий газар, Мал эмнэлгийн ерөнхий газар
4	Санхүүжүүлэгч байгууллага:	Азийн хөгжлийн банк
5	Төслийн нийт санхүүжилт:	АХБ-ны хөнгөлөлттэй зээл 15 сая ам.доллар, Монгол Улсын Засгийн газар НӨАТ, Гаалийн татвар чөлөөлөх хэлбэрээр 1.25 сая ам. Доллар
6	Төсөл хэрэгжих хугацаа:	2016 оны 2 сарын 08-наас 2025 оны 11 сарын 10 хүртэл
7	Төсөл, арга хэмжээний зорилго:	Дэлхийн худалдааны байгууллагын “Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах хэлэлцээр”-т нийцүүлэн Монгол Улсын ургамал, малын эрүүл ахуйн хяналтын тогтолцоог сайжруулах, хөдөө аж ахуйн болон хүнсний бүтээгдэхүүний олон улсын худалдааг дэмжих замаар эдийн засгийн өсөлтөд хувь нэмэр оруулах зорилготой.
8	Төслийн бүрэлдэхүүн хэсгүүд:	Төсөл 4 бүрэлдэхүүн хэсэгтэй: Бүрэлдэхүүн хэсэг 1: Лаборатори болон хорио цээрийн байгууламжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх; Бүрэлдэхүүн хэсэг 2: <i>Хилийн хяналтын удирдлагын систем – програм хангамж боловсруулах зөвлөх үйлчилгээ; (2022 оноос Ургамал, мал, хүнсний эрүүл ахуй, хорио цээрийн хилийн хяналтын үйл ажиллагааг цахимжуулан, Гаалийн автоматжуулсан мэдээллийн системд нэгтгэх зөвлөх үйлчилгээ болж өөрчлөгдсөн);</i> Бүрэлдэхүүн хэсэг 3: Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлын хяналт, шалгалтыг олон улсын стандартад нийцүүлэх; Бүрэлдэхүүн хэсэг 4: Төслийн удирдлага;

Бүрэлдэхүүн хэсэг 2:

Хилийн хяналтын удирдлагын систем - програм хангамж боловсруулах зөвлөх үйлчилгээ;

Төслийн гүйцэтгэгч нэгж: Интерактив ХХК

Хилийн хяналтын удирдлагын систем төсөл”-ийг дараах 9 үе шатаар хэрэгжүүлж байна. Үүнд:


Төслийн эхлэлийн үе шат (1 хувь), Төсөл төлөвлөх үе шат (2 хувь), Одоогийн нөхцөл байдлын судалгааны үе (10 хувь), Системийн байх ёстой загвар гаргах үе шат (21 хувь), Кодчилал, хөгжүүлэлэлтийн үе шат (38 хувь), Суурилуулах, бета тестийн үе шат (12 хувь), Сургалт хийх, гарын авлага бэлтгэх (10 хувь), Хүлээлгэн өгөх тест, нэвтрүүлэлтийн үе шат (5 хувь), Төслийн хаалтын үе шат (1 хувь)-аар тооцон 2025 оны 04 дүгээр сарын 30-аар гаалийн байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэхээр төлөвлөсөн.

Хилийн хяналтын удирдлагын систем


Хилийн хяналтын удирдлагын системийг CAIS системтэй уялдуулан хөгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэж дууссан ба дараах голлох үр дүн гарна: Үүнд

- Гаалийн байгууллагын хяналт шалгалтад нэн шаардлагатай хүнсний бараа, бүтээгдэхүүний “Бар код” лавлах сан;
- Гаалийн бүрдүүлэлтийн модульд нэмэлт хөгжүүлэлт хийж, хорио цээрийн хяналт шалгалтын онцлогтой холбоотой нэмэлт талбарууд оруулах;
- Амьтан, ургамлын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд олгосон импортын мэдэгдлийг мэдээллийг бүртгэж, тус бүртгэлийн дагуу иргэн, хуулийн этгээд импортын гэрчилгээг цахимаар лавлагаа байдлаар авах, түүхчилсэн лавлагаа үүсэх, тэмдэгтийн хураамжийг төлбөрийн олон боломжоор шууд төлөх, гэрчилгээний тооцоог цахимаар хийх;
- Эрүүл ахуй, хорио цээр, чанарын тохирлын хяналттай холбоотой хяналт шалгалттай холбоотой бүртгэл, хариу арга хэмжээний статистик мэдээ, мэдээллийг цахимаар солилцох (Зорчигчийн эм, гэрийн тэжээвэр амьтан, цацраг, шарил, яаралтай сэрэмжлүүлэг мэдэгдэл, ОУ-ын хөл хориот өвчний халвартай бүс нутгийн бүртгэл ...)
- Хорио цээрийн хяналт шалгалтад ашиглаж буй “Хяналтын хуудас”-ыг цахим хэлбэрт шилжүүлэн тогтмол шинэчлэн ашиглах “Хяналт шалгалтын заавар”-ыг нэвтрүүлэх;
- Гаалийн хорио цээрийн хяналт шалгалттай холбоотой гэрчилгээ, халдваргүйжүүлэлтийн төлбөрийг ПОС, QR код уншуулж төлдөг болох;
- Төрийн болон бусад байгууллагатай мэдээллийг бодит цагийн горимоор солилцох;
- Гаалийн хяналтын бүс, талбайд ажиллаж байгаа гаалийн улсын байцаагч, иргэн, хуулийн этгээд ашиглах гар утасны 2 төрлийн аппликейшнтай болох зэрэг олон боломжийг бүрдүүлж, гадаад худалдааг хөнгөвчлөх ахиц гаргана.

Хилийн хяналтын удирдлагын системийн хүрээнд шинээр боловсруулах, өөрчлөн сайжруулах програм хангамжийн модулиуд



Гаалийн хорио цээрийн функци, үйл (SPS) ажиллагааг нэгтгэн цахимжуулах ерөнхий схем



Гаалийн автоматжуулсан мэдээллийн системд өгөгдөл боловсруулалт хийгдэх схем (өргөтгөл хийсний дараа)

